



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 02 сарын 15 өдөр

Дугаар 0/48

Хэрлэн сум

Малын гоц халдварт хонины цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай" хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5, 4.5.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Өмнөдэлгэр, Жаргалтхаан, Хэрлэн, Мөрөн, Баянхутаг, Баян-Адрага, Биндэр сумдад малын гоц халдварт хонины цэцэг өвчин оношлогдсонтой холбогдуулан уг өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд онцгой ач холбогдол өгч мэдрэмтгий малыг бүрэн хамруулах ажлыг тарилга хүлээн авсан өдрөөс эхлэн 14 хоногт багтаан чанартай зохион байгуулахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

Хоёр. Хонины цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтанд шаардлагатай вакцин, мэргэжил арга зүйн заавар, зөвлөмжөөр хангаж ажиллахыг Хүнс, Хөдөө аж ахуйн газар /Ж.Энх-Амгалан/-т даалгасугай.

Гурав. Урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын явц, гүйцэтгэлд хяналт тавьж, тарилгын тооцоо, бичиг баримтыг Хүнс, Хөдөө аж ахуйн яаманд хугацаанд нь хүргүүлж, тарилгын дүнг тухай бүр танилцуулж ажиллахыг Хүнс, Хөдөө аж ахуйн газар /Ж.Энх-Амгалан/, Мэргэжлийн хяналтын газар /Б.Сүнгээ/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

01 317